



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 304

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын 1997 оны 52, 2012 оны 142 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан цол тэмдэг болон Сангийн яамны шагнал олгох" журмыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Р.Гансүх)-т даалгасугай.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Сангийн сайдын 2006 оны 198 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ч.УЛААН

000732

ЗАСГИЙН ГАЗРЫН САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН ЦОЛ,  
ТЭМДЭГ БОЛОН САНГИЙН ЯАМНЫ ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

**Нэг. Ерөнхий зүйл**

1. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан тэмдэг болон Сангийн яамны шагнал олгоход энэхүү журмыг мөрдөнө.

2. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан тэмдэг болон Сангийн яамны шагналын үндсэн зорилго нь Монгол Улсын санхүүгийн салбар болон банк, гааль, татвар, нягтлан бодох бүртгэл, аудит, даатгалын байгууллагын ажилтан нарын хөдөлмөрийн ололт амжилт, үр бүтээлийг үнэлэх, тэдний идэвхи санаачилгыг хөхүүлэн дэмжиж, сайшаан урамшуулахад оршино.

3. Шагналыг олгохдоо тус салбарын ажилтны ажлын ололт амжилт, үр бүтээлийг гол шалгуур үзүүлэлт болгохын зэрэгцээ тухайн ажилтны ажилладаг байгууллага, газар, хэлтэс болон хамт олны томоохон бүтээн байгуулалт, ажлын үр дүнг харгалзан үзэх зарчмыг баримтална.

4. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан цол, тэмдэг болон Сангийн яамны шагнал дараах төрөлтэй байна:

- 4.1. “Санхүү, банкны тэргүүний ажилтан” тэмдэг;
- 4.2. “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан” тэмдэг;
- 4.3. “Гаалийн албаны тэргүүний ажилтан” тэмдэг;
- 4.4. Сангийн яамны Хүндэт дэвтэрт бичиж, дурсгалын гэрчилгээ олгох;
- 4.5. Санхүү, эдийн засгийн албаны Хүндэт тэмдэг;
- 4.6. Сангийн яамны Жуух бичиг;
- 4.7. Мөнгөн шагнал буюу үнэ бүхий зүйлээр шагнах.

**Хоёр. Шагнал олгох ерөнхий нөхцөл**

2.1. Санхүүгийн салбар болон банк, аудит, даатгал, гааль, татварын албанд 5-аас доошгүй жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан ажилтныг Сангийн яамны Жуух бичгээр шагнаж, урамшуулна.

2.2. Санхүүгийн салбар болон банк, аудит, даатгал, татварын албанд 15-аас доошгүй жил мэргэжлээрээ идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан ажилтныг “Санхүү, банкны тэргүүний ажилтан” тэмдгээр, бүртгэл, санхүүгийн албанд 15-аас доошгүй жил мэргэжлээрээ үр бүтээлтэй ажилласан ажилтныг “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан” тэмдгээр, гаалийн албанд 15-аас доошгүй жил мэргэжлээрээ идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан ажилтныг “Гаалийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах ерөнхий нөхцөлийг тус тус хангасан гэж үзэж, шагнуулахаар тодорхойлно.

2.3. Санхүү, эдийн засаг, банкны төв, орон нутгийн байгууллагад 00-аас доошгүй жил ажиллаж, салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, хөдөлмөрийн өндөр амжилт, үр бүтээл гаргасан удирдах ба ахмад ажилтны алдар гавъяа, сайн үйлс, үлгэр дууриаллыг алдаршуулж, Сангийн яамны Хүндэт дэвтэрт

алдар нэрийг нь мөнхжүүлэн бичиж үлдээнэ. Хүндэт дэвтэрт бичигдсэн тухай гэрчилгээ олгоно. Сангийн яамны Хүндэт дэвтэрт бичигдэх ажилтан салбарын тэргүүний ажилтан тэмдгээр шагнагдсан байна.

2.4. Санхүү, банк, эдийн засгийн салбарт 25-аас доошгүй жил ажлын өндөр амжилт гарган ажиллаж байгаа болон тэтгэвэрт байгаа ахмад ажилтан нарыг Санхүүгийн эдийн засгийн албаны Хүндэт тэмдгээр шагнаж, урамшуулна.

2.5. Монгол улсын санхүү, банк, нягтлан бодох бүртгэл, гааль, татвар, аудит, даатгалын салбарыг хөгжүүлэн бэхжүүлэх үйл хэрэгт онцгой амжилт, шинэ санаачилга, бүтээл гаргасан, улс орны хэмжээний нээлт хийсэн /түүнийг хэрэгжүүлснээр улс, нийгэмд тодорхой ашиг тус өгсөн бол/ ажилтныг энэ журмын 2.1-2.4-т заасан хугацааг харгалзахгүйгээр шагнаж, урамшуулж болно.

2.6. Монгол улсын санхүүгийн албыг хөгжүүлэн бэхжүүлэх үйл хэрэгт онцгой амжилт гаргасан, санхүү, эдийн засгийн бодитой дэмжлэг туслалцаа үзүүлсэн гадаадын иргэнийг дээрх шагналаар шагнаж, урамшуулж болно.

2.7. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан тэмдэг болон Сангийн яамны шагналыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдын тушаалаар олгоно.

### **Гурав. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан тэмдэг болон Сангийн яамны шагналд тодорхойлох, түүнийг хүлээн авах, шийдвэрлэх**

3.1. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан тэмдэг болон Сангийн яамны шагналаар шагнуулахаар өргөн мэдүүлж байгаа ажилтны ажил байдлын тодорхойлолтод тухайн ажилтны сүүлийн 3-5 жилийн ажлын ололт амжилт, үр бүтээл, ажлын гол үзүүлэлт, хүрсэн үр дүн, улмаар байгууллагын дүгнэлтийг тусгасан байна.

3.2. Шагналын тодорхойлолтод байгууллагын дарга, эрхлэгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан дараахь баримт бичгийг хавсаргаж, харьяа аймаг, нийслэл, дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлнэ.

3.2.1. Шагнуулахаар өргөн мэдүүлсэн хүний анкет, ажил байдлын тодорхойлолт;

3.2.2. Шагнуулах тухай үндсэн байгууллагын хүсэлт;

3.2.3. Шагнуулах тухай хүсэлтийг дэмжсэн хамт олны хурлын тэмдэглэл;

3.2.4. Аж ахуйн нэгж бол өөрийн харилцдаг аймаг, нийслэл, дүүргийн татварын албаны тодорхойлолт;

3.3. Аймаг, нийслэл, дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэс байгууллагаас ирүүлсэн шагналын тодорхойлолтыг энэ журмын 2.1-2.5 дахь заалтын дагуу хянан үзэж, Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан тэмдэг болон Сангийн яамны шагналаар шагнуулах хүсэлтээ Санхүү, эдийн засагчдын өдөр, Үндэсний их баяр наадам болон бусад тэмдэглэлт баяр болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө Сангийн яаманд ирүүлнэ.

3.4. Шагналыг Үндэсний их баяр наадам, санхүү, эдийн засагчдын өдөр болон тухайн салбарын байгууллагын түүхт тэгш ойн өдрийг тохиолдуулан олгоно.

3.5. Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар шагнуулах тухай хүсэлт, тодорхойлолтыг хүлээн авах, түүнийг хянан нягтлах, шагнах шийдвэр гаргуулах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

3.6. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан тэмдэг болон Сангийн яамны шагнал олгох (энэ журмын 2.1-2.6 дах заалтад заасан) ерөнхий нөхцлийг хангаагүй тохиолдолд материалыг буцаана.

3.7. Ажилтны шагналын тодорхойлолт, түүнд холбогдох баримт бичгийг энэ журмын 3.3-т заасан хугацаанаас хойш ирүүлсэн тохиолдолд шагнал олгох эсэх асуудлыг дараагийн тушаал гарах хүртэл хойшлуулна.

3.8. Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар шагнагдсан ажилтны нэгдсэн бүртгэлийг хөтөлнө.

### **Дөрөв. Шагналын хэмжээ**

4.1. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан тэмдэг болон Сангийн яамны шагналын дагалдах мөнгөн шагналыг Засгийн газрын 2012 оны 142 дугаар тогтоолыг үндэслэн тухайн ажилтныг шагнуулахаар тодорхойлсон үндсэн байгууллагаас нь гаргана.

4.2. “Санхүү, банкны тэргүүний ажилтан”, “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан”, “Гаалийн тэргүүний ажилтан” тэмдгийн дагалдах мөнгөн шагнал 100 000 /нэг зуун мянган/ төгрөг, Сангийн яамны Хүндэт дэвтэрт бичиж, дурсгалын гэрчилгээ олгоход дагалдах мөнгөн шагнал 200 000 /хоёр зуун мянган/ төгрөг, Сангийн яамны Жуух бичиг болон Санхүүгийн, эдийн засгийн албаны Хүндэт тэмдгийг дагалдах мөнгөн шагнал 10 000 /арван мянган/ төгрөг байна.

### **Тав. Засгийн газрын салбарын тэргүүний болон Сангийн яамны шагналын тэмдэг, үнэмлэхийг нөхөн болон сольж олгох**

5.1. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан тэмдэг болон Сангийн яамны шагналын үнэмлэх, тэмдэгийг ямар нэг шалтгаанаар үрэгдүүлсэн, эвдэж гэмтээсэн тохиолдолд шагналын эзэн, түүний нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүд нь зохих үнээр нь нөхөн болон сольж олгож болно.

5.2. Үнэмлэх, тэмдэгийг шагналын эзэн, түүний нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү нөхөн болон сольж авахыг хүсвэл үрэгдүүлсэн, эвдэж гэмтээсэн нөхцөл, шалтгааныг тодорхой бичсэн өргөдлөө үнэмлэх, тэмдгийн үнийг банкинд тушаасан баримт, эвдэрч гэмтсэн зүйлийн хамт Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.

30. Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар өргөдлийг хянан үзэж тэмдэг, үнэмлэхийг нөхөн болон сольж олгох үндэслэлтэй гэж үзвэл нөхөн олгоно.

САНГИЙН ЯАМНЫ ШАГНАЛААР ШАГНУУЛАХААР  
ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХҮНИЙ АНКЕТ

1. Овог:
2. Нэр:
3. Төрсөн огноо:
4. Хүйс:
5. Төрсөн аймаг, сум, хот:
6. Одоогийн харъяалал:
7. Регистрийн дугаар:
8. Ажилладаг салбар:
9. Мэргэжил:
10. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

№	Ажлын газрын нэр	Хугацаа /оноор/	Эрхэлсэн ажил, албан тушаал
1			
2			
3			
4			

12. Урьд нь шагнагдаж байсан шагналууд  
/Монгол Улсын цол, одон медаль, салбарын болон яамны шагнал/

№	Шагналын нэр	Хэдэн онд
1		
2		
3		
4		

13. Нэр дэвшүүлж байгаа шагналын нэр:  
14. Шагнуулах үндэслэл: